



ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:
МОНГОЛЫН БАЛЕТЫН ХӨГЖИЛ САН
БАЛЕТЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО

МОНГОЛЫН БАЛЕТЫН ҮНДЭСНИЙ IV УРАЛДААНЫ ЖУРАМ

1. БҮРТГЭЛ БА ШАЛГАРУУЛАЛТЫН ХУГАЦАА.....	2
2.УРАЛДААНЫ ЗОРИЛГО.....	2
3. ХАМРАХ ХҮРЭЭ БА ОРОЛЦОХ НӨХЦӨЛ.....	2
4. НАСНЫ АНГИЛАЛ БА ОРОЛЦОХ ТӨРЛҮҮД.....	2
5. БҮРТГЭЛ БА БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ.....	3
6.САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ХҮСЭХ.....	4
7. ЗОХИОГЧИЙН ЭРХ.....	4
8. УРАЛДААНЫ ШИЙДВЭР ГАРГАГЧИД.....	4
9.УРАЛДААНЫ ҮЕ ШАТ.....	5
10.ШҮҮЛТИЙН ОНЦЛОГ.....	5
11. ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	5
12.ШАГНАЛЫН САН.....	6
13.ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЖУРАМ.....	7
14. ХУУЛЬ ДҮРЭМ.....	7
ШҮҮГЧДИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	8
ХАВСРАЛТ 1	
ХАВСРАЛТ 2	

1. БҮРТГЭЛ БА ШАЛГАРУУЛАЛТЫН ХУГАЦАА

Уралдааны бүртгэл 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны хооронд явагдаж шалгаруулалт 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 28-ны өдрүүдэд цахим буюу бичлэг хэлбэрээр явагдана.

2. УРАЛДААНЫ ЗОРИЛГО

Монголын балетын үндэсний уралдаан нь балетаар хичээллэгч хүүхэд залуучуудын ур чадварыг сайжруулах, сурах орчин нөхцөлийг дэмжих, балетын студи, байгууллагуудын болон сурагчдын харилцаа холбоог үүсгэх, улмаар авьяас чадвараа цааш хөгжүүлэх, гадаад дотоодын тэмцээн уралдаан, сургалт, тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг нээх зорилготой жил бүр зохион байгуулагддаг болно.

3. ХАМРАХ ХҮРЭЭ БА ОРОЛЦОХ НӨХЦӨЛ

Улсын хэмжээнд балетаар хичээллэж буй 6-18 насны сурагч, оюутнууд, гадаад улсад амьдарч буй тохирох насны Монгол сурагчид, мөн Монгол дахь балетын сургууль болон студид суралцагч гадаадын иргэд оролцох боломжтой.

Уралдаанд оролцогчдын унаа, байр, хоолны зардлыг тухайн байгууллага болон хувь хүн өөрөө хариуцна. Уралдаанд оролцох үед, дасгал сургуулилт, бичлэг хийх явцад гэмтэл бэртэл авсан тохиолдолд оролцогч өөрөө хариуцах тул эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэхээ шалгаж, анхаарал болгоомжтой оролцоно.

4. НАСНЫ АНГИЛАЛ БА ОРОЛЦОХ ТӨРЛҮҮД

Сонгодог балетын ГАНЦААРЧИЛСАН ТӨРӨЛ:

- 9-11 нас (бэлтгэл нас),
- 12-14 нас (өсвөр нас 1),
- 15-18 нас (өсвөр нас 2) ангиллаар явагдана.

Ганцаарчилсан төрөлд оролцогч нь насаар 2021 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар оролцох ангиллын хамгийн бага хязгаарт хүрсэн, дээд хязгаараас хэтрээгүй байна.

Сонгодог балетын БАГИЙН ТӨРӨЛ:

- 6-8 нас (бага нас),
- 9-11 нас (бэлтгэл нас),
- 12-14 нас (өсвөр нас 1) ангиллаар явагдана.

Багийн гишүүдийн 60-аас дээш хувь нь насаар 2021 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар насны ангиллынхаа доод хязгаарт хүрсэн, дээд хязгаараас хэтрээгүй байх бөгөөд 3 болон 3-аас дээш гишүүдээс бүрдэнэ.

БҮЖГИЙН БИЧЛЭГ

ГАНЦААРЧИЛСАН ТӨРӨЛ-д дараах байдлаар оролцоно:

- Бэлтгэл насны (9-11) сурагчид 1 сонгодог балетын гоцлол бүжгийн бичлэг
- Өсвөр 1 (12-14) насны сурагчид 1 танхимын дасгал бүхий бичлэг /10 минутаас хэтрэхгүй/, 2 сонгодог балетын гоцлол бүжгийн бичлэг
- Өсвөр 2 (15-18) насны сурагчид 1 танхимын дасгал бүхий бичлэг /10 минутаас хэтрэхгүй/, 2 сонгодог балетын гоцлол бүжгийн бичлэг/ па де де-гээр оролцох бол 1 бичлэг/, 1 орчин үеийн бүжгийн бичлэг тус тус бэлдэж оролцоно. Өсвөр нас 2 ангилал буюу 15-18 насны оролцогчид гоцлол эсвэл па де де-гээр оролцох боломжтой.

Зөвхөн уралдаанаас зөвшөөрөгдөж буй вариациудаас сонгон хийнэ. (Хавсралт 2-ыг үзнэ үү.)

Орчин үеийн бүжиг нь модерн, этник, неоклассик, контемпорари бүжгүүд байж болох бөгөөд 1 минут 30 секундээс 2 минут 30 секундын хооронд, дуэт бол 3 минутаас 6 минутанд үргэлжилнэ. Орчин үеийн бүжгийг дэглээчтэй хамтран бэлдэх, орчин үеийн бүжгийн дэглээчээс зөвшөөрөл аван бүтээлийг нь ашиглан бэлдэх, өөрийн дэглэлтээр хийх боломжтой.

БАГИЙН ТӨРӨЛ-д дараах байдлаар оролцоно:

Бага нас (6-8),

Бэлтгэл нас (9-11),

Өсвөр нас 1 (12-14)

ангиллын оролцогчид Багийн бүжгийн 1 бичлэг бэлдэж оролцоно. Үргэлжлэх хугацаа 2 минутаас 4 минут.

Бэлдсэн файлуудаа өөрийн ОВОГ НЭР, БҮЖГИЙН НЭР, НАСНЫ АНГИЛАЛ гэсэн байдлаар нэрлэсэн байх шаардлагатай.

5. БҮРТГЭЛ БА БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Уралдааны бүртгэл 2021 оны 10 дугаар сарын 15-наас 11-р сарын 15-ны өдрүүдэд үргэлжилнэ. Энэ хугацаанд ангиллаас шалтгаалж, бүх оролцогчид толгой мөр гарсан, сүүлийн 1 жилд авахуулсан 1 ширхэг цээж зураг, бүтэн бие гарсан, бүжгийн зогсолттой зураг 1 ширхэг, төрсний гэрчилгээний хуулбар, дасгалын бичлэг, тэмцээнд орох бичлэгүүдийг www.mongolianballet.mn хаяг дахь цахим бүртгэлийн хуудсаар оруулан, хувийн мэдээллийг бөглөн явуулна. Уралдааны бүртгэлийн хуудас руу хялбар орох QR код:



Оролцогчид бүртгэлийн хураамж болох 80,000 төгрөгийг интернет банк ашиглан 5003762200 Монголын балетын хөгжил сан (Хаан банк) дансанд 2021 оны 10 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 15-ны хооронд шилжүүлсэн байна. Гүйлгээний утга дээр оролцогчийн овог нэр, насны ангилал, холбоо барих утасны дугаарыг зөв, тодорхой бичсэн байна. Уралдаанд нэгээс дээш бүжгийн төрөлд оролцох бол нэмэлт хураамж төлөхгүй. Бүртгэлийн хураамжийг буцаах боломжгүй ба оролцогч зөвхөн эрүүл мэндийн шалтгаанаа бичгээр мэдэгдэн эмчийн бичгийг ирүүлсэн тохиолдолд буцаана.

Бүртгэлийн хугацаанаас хоцорсон оролцогчийн бүртгэлийн хуудас, бичлэг болон бусад материалыг хүлээж авахгүй болно.

6. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ХҮСЭХ

Уралдааны бүртгэлийн хураамжийг төлөх боломжгүй хүндэтгэх шалтгаантай бол санхүүгийн дэмжлэг авах хүсэлтийг уралдаан зохион байгуулах хороонд 2021 оны 11-р сарын 1-ний өдрийн дотор ирүүлэх боломжтой. Оролцогчийн эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс өргөдөл, багшийн өргөдөл, шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар гэх зэргийг mibc@mongolianballet.com цахим хаягаар дээрх хугацаанд ирүүлнэ үү. Ажлын 5-7 хоногт хариуг имэйлээр илгээх болно.

7. ЗОХИОГЧИЙН ЭРХ

Уралдааны үеэр хийгдсэн зураг, бичлэг, нэвтрүүлэг буюу бүхий л төрлийн дижитал болон биет бүтээл, бүтээгдэхүүнүүд нь Монголын балетын үндэсний уралдааны өмч болох бөгөөд оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан болно. Уралдааны зураг, бичлэгийг оролцогчдод өгөх хариуцлага үүрэхгүй бөгөөд, боловсрол, мэдээлэл, зар сурталчилгааны зориулалттайгаар ашиглах бүрэн эрхтэй.

8. УРАЛДААНЫ ШИЙДВЭР ГАРГАГЧИД

Уралдааны дүрэм журамд зөвхөн уралдааны захирлын шийдвэрээр өөрчлөлт оруулах боломжтой.

Уралдааны дүнг шүүгчдийн бүрэлдэхүүн шийдвэрлэх бөгөөд эцэслэгдсэн дүнг буцаах, өөрчлөх боломжгүй болно.

Уралдааныг Монгол улсын болон олон улсын нэр бүхий мэргэжилтнүүд шүүн явуулна. Шүүгчдийн мэдээллийг www.mongolianballet.mn хуудаснаас 2021 оны 10-р сард мэдэх боломжтой.

9. УРАЛДААНЫ ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ

2021.11.16-11.21

Уралдааны 1-р шат нь ганцаарчилсан төрөлд оролцогч Өсвөр 1 (12-14 нас) болон өсвөр 2 (15-18 нас) ангиллын дасгалын бичлэгийн шалгаруулалтаас бүрдэнэ.

2021.11.22-11.24

Уралдааны 2-р шат ганцаарчилсан төрлийн Өсвөр 1 (12-14 нас), Өсвөр 2 (15-18) насны сонгодог бүжгийн шалгаруулалт, мөн Өсвөр 2 (15-18 нас) ангиллын орчин үеийн бүжгийн хэсгүүдээс бүрдэнэ.

2021.11.25-11.28

Уралдааны 3-р шат нь Бэлтгэл (9-11 нас) ангиллын гоцлол бүжиг, 6-8, 9-11, 12-14 насны ангиллын багийн төрлийн бүжгүүдийн шалгаруулалт болон 2-р шатнаас шалгарсан Өсвөр 1, Өсвөр 2 насны ангиллын оролцогчдын 2 дахь сонгодог бүжгийн бичлэгээс бүрдэнэ. Энэ шат нь финалын шат бөгөөд шагналт байруудыг уралдааны цахим хуудас болон Монголын балетын хөгжил сангийн нүүр хуудсаар зарлана.

**Дээрх хугацаанд нөхцөл байдлаас шалтгаалж бага зэргийн өөрчлөлт орж болзошгүй болно.*

10. ШҮҮЛГИЙН ОНЦЛОГ

Эцсийн шатанд оролцогчдын 1,2,3-р шатны нийлбэр дүнгээр шалгаруулалт хийгдэж дүн гарна. Уралдааныг шүүх явцад оноо тэнцэх буюу маргаантай асуудал гарсан тохиолдолд ерөнхий шүүгчийн шийдвэр эцсийн шийдвэр байна.

Оноожуулах систем:

Үзүүлэлт тус бүр 1-10 хүртэл тоон үзүүлэлтээр оноог дүгнэнэ.

11. ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ганцаарчилсан төрөлд оролцогчид дараах үзүүлэлтүүдийг анхаарна:

- 1) Хөгжим, сонсгол
- 2) Ур чадвар
- 3) Техник
- 4) Жүжиглэлт



- 5) Гүйцэтгэл
- 6) Хувцаслалт
- 7) Гоо зүй
- 8) Тайзны соёл

Зөвлөмж: Үзүүлбэрээ зөв, цэвэрхэн гүйцэтгэх, шат шатны техникүүдээ түүртэхгүй биедээ оруулсан байх нь давуу тал болно.

Багийн төрөлд оролцогчид дараах үзүүлэлтүүдийг анхаарна:

- 1) Хөгжим, сонсгол
- 2) Ур чадвар
- 3) Техник
- 4) Жүжиглэлт
- 5) Гүйцэтгэл
- 6) Хувцаслалт
- 7) Гоо зүй
- 8) Тайзны соёл
- 9) Бүжгийн анхан шатны элементүүд орсон байх
- 10) Зэрэг гүйцэтгэл

Зөвлөмж: Тайзан дээр төрөл бүрийн хайрцаг гаргах, ямар нэг үлгэр сэдэвлэх, уран сэтгэмж, жүжиглэлт үзүүлэх нь давуу тал болно.

ХУВЦАСЛАЛТ

Вариацийн бичлэг хийхдээ дүрийн бүрэн хувцастай байна. Орчин үеийн бүжгийг хийхдээ дүрийн дагуу хувцаслалт, эсвэл дасгалын хувцастай гүйцэтгэж болно. Ганцаарчилсан төрөлд оролцогч 12-с дээш насны хүүхдүүд дасгалын бичлэгийг хийхдээ дасгалын хувцастай байна.

12. ШАГНАЛЫН САН

Багийн төрөл: Бага нас, Бэлтгэл нас, Өсвөр нас 1 ангилал тус бүр

Алтан медаль : Батламж, 600,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг
Мөнгөн медаль: Батламж , 500,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг
Хүрэл Медаль: Батламж , 400,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Ганцаарчилсан төрөл: Бэлтгэл нас, Өсвөр нас 1 ангилал тус бүр

Алтан медаль : Батламж, 600,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг
Мөнгөн медаль: Батламж , 500,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг



Хүрэл Медаль: Батламж , 400,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Ганцаарчилсан төрөл: Өсвөр нас 2 ангилал

Алтан медаль : Батламж, 800,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Мөнгөн медаль: Батламж , 600,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Хүрэл Медаль: Батламж , 500,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Тусгай байр: Батламж, 100,000 төгрөгийн дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Шилдэг багшийн “Балетын төлөө” шагнал:

1-р байр: Батламж, 500,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

2-р байр: Батламж, 400,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

3-р байр: Батламж, 300,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Тусгай байр: Батламж, 150,000 төгрөгийн дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Орон нутгаас оролцогчдыг дэмжих “Балетад хайртай” шагнал:

1-р байр: Батламж, 500,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

2-р байр: Батламж, 400,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

3-р байр: Батламж, 300,000 төгрөг, дасгалын хувцас хэрэгсэл бүхий бэлэг

Шилдэг зохион байгуулалт шагнал / менежментийн баг/:

1-р байр: Батламж, 500,000 төгрөг

2-р байр: Батламж, 400,000 төгрөг

3-р байр: Батламж, 300,000 төгрөг

Мөн улсын болон олон улсын уралдаан, сургалт, тэтгэлэгт хөтөлбөрүүдийн эрхийн бичиг, урилгууд багтана.

Уралдааныг дэмжигчдийн нэг болох Хаан Банкнаас Монголын балетын нүүр царай болох шилдэг оролцогчийг шалгаруулж хамтран ажиллах урилга мөн олгоно.

13. ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЖУРАМ

Уралдааны шүүгчдийн бүрэлдэхүүн аливаа насны ангилал болон төрөлд шагналын санд дурдагдсан шагналыг олгох эсэх эцсийн шийдвэрийг гаргана. Ангилал болон төрлийн оролцогчдын тоо, ур чадварыг харгалзан энэхүү шийдвэрийг гаргана. Уралдааны удирдах зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр, шүүгчдийн зүгээс болон уралдааныг дэмжигчдийн зүгээс нэмэлт шагнал урамшуулал, урилга болон тэтгэлэг олгогдох боломжтой. Мөнгөн шагналыг хууль дүрмийн дагуу татвар суутган олгоно.


14. ХУУЛЬ ДҮРЭМ

Уралдааныг зохион байгуулах, уралдаанд оролцоход Монгол улсын холбогдох бүх хууль дүрмийг баримтална.

ШҮҮГЧДИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Хүндэт шүүгч: Балжинням Жамъяндагва

/Монгол улсын ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар/



Ерөнхий балетмейстер, Төрийн шагналт, Ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар, Хөгжмийн театрыг үндэслэгчдийн нэг.

1962 онд ОХУ-ын Москва хотын А.В.Луначарскийн нэрэмжит ТУДС-ийг хөгжмийн театрын найруулагч, балетмейстер мэргэжлээр төгссөн. УДБЭТ-т 2001 оноос 2013 он уран сайхны удирдагчаар, 1963 оноос одоог хүртэл ерөнхий балетмейстрээр тасралтгүй ажиллаж байна.

1976 оноос өнөөдрийг хүртэл тасралтгүй төр засгийн хүндэтгэлийн болон түүхт ой, ёслол арга хэмжээний олон арван концертыг найруулан ажиллаж байна.

Дугараа Алтанхуяг

/МУГЖ, Соёлын элч/



Цөмөөхэй балет төслийг 2014 оноос хойш жил санаачлан зохион байгуулж, удирдан, найруулсан.

2012-2018 онд “Winter star-2012”, “Модерн бүжгийн үдэш” олон улсын наадам, “Монголд тавтай морил” олон улсын балетын фестиваль, Япон Улсын “Комаки Балет” компанийн тоглолт, “Монгол Бахархал”, “Цөмөөхэй” балет 2014, 2015, 2016, 2017, 2018, 2019 тоглолтуудыг эх орондоо санаачлан УДБЭТ, Корпорейт сентерт зохион байгуулж, оролцсон.

2015 оноос Нью Йорк хотноо Cirio Collective компанийг санаачлан 2016, 2017 онуудад АНУ-аар томоохон хотуудаар аялан тоглосон.

Одоогоор Монголын балетын хөгжил сангийн тэргүүн, Монголын балетын үндэсний сургуулийн захирлаар ажиллаж байна.

Дорж Алтантуяа
/МУСТА/



1975-1983 онд ЗХУ ын Пермь хотын Сонгодог бүжгийн сургуулийг Балетийн жүжигчин
1999-2003 онд СУИС-ийг багш-балетмейстер /бакалавр/
2006-2009 онд СУИС-ийн Урлаг судлалын ухааны магистр
1983-2009 онд ДБЭТеатрт гоцлол балетийн жүжигчин
1994-1995 онд ХБКоллежид Сонгодог бүжгийн багш
2004-2006 онд ХБКоллежид Сонгодог бүжгийн багш
1996-1997 онд 135-р цэцэрлэгийн бүжгийн сонгон ангид багш
2005- 2013 онд СУИС-ийн БУНТэнхимд Сонгодог бүжгийн багш
2013-2015 онд СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуулийн ЭНБДарга
2015-оноос СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуулийн Найруулах урлагийн тэнхимийн эрхлэгч

Доржбат Одмаа
/МУСТА/



1981~1989 ЗХУ-ын Пермь хотын Бүжгийн Тусгай Сургууль дүүргэсэн.
2004 Пермь Бүжгийн сургуулийн Балетын 1~4 ангид заах аргын сургалт
2017 Оросын Перербург хотын Ваганова Балетын 1~4 ангид заах аргын сургалт
2014~2018 Монгол Улсын СУИС бакалавр



1997 Монгол Улсын Дуурь Бүжгийн Академик театрт гоцлол бүжигчнээр ажилсан.
1998 оноос хойш Солонгосын "L" Ballet, Kim Hee Yeon, Lee Myeon Jin, Hwang Yun Hei, хувийн сургууль,
Шагнал урамшуулал: 2011 Hanyang University Ballet Competition уралдаанаас шилдэг багш
2019 Солонгос Hwaseon хотын даргын нийгмийн идэвхтэн шагнал
Одоо ажиллаж байгаа газар: "JIN ART CENTER" балетын ахлах багш, Монголын Балетын Холбооны гишүүн.

Ганбаатар Цолмон

/МУГЖ, Улсын Дуурь бүжгийн Эрдмийн театрын гоцлол бүжигчин/



1984 онд ОХУ-ын Санкт-Петербург хотын А.Я.Вагановагийн нэрэмжит балетын Академид элсэн орсон. 1992 онд УДБЭТ-д балетийн жүжигчнээр ажилласан. 1996 оноос хойш гоцлол бүжигчнээр ажиллаж эхэлсэн.

Айлчлан тоглолт

2009 онд Японы Комаки балетын урилгаар айлчлан тоглосон

2012 онд Хятадын Тьянжин хотод айлчлан тоглосон

2019 онд Солонгос улсын WISE балетын жүжигчидтэй Жизель бүжгэн жүжгийг хамтарч тоглосон.

2019 онд Японы Токио хотод зохион байгуулагдсан PIBC балетын тэмцээний шүүгчээр ажилласан.

Со Кикүчи

/Олон Улсын Балетын Академиягийн үүсгэн байгуулагч, захирал/



Олон Улсын Балетын Академийн ерөнхийлөгч, Токио Комаки Балетын ерөнхий захирал асан

Тэрээр Масахидэ Комаки, Тадао Кикүчи нарын удирдлаган дор суралцсан.

2012 онд Монгол улсын Ерөнхий Сайдын урилгаар Япон-Монголын 40 жилийн дипломат харилцааны ойд зориулсан тоглолт /Олон Улсын Соёл Урлагийн Солилцооны Агентлаг/

Монгол улсын Ерөнхий сайдын нэрэмжит шагнал

2015 онд олон улсын солилцоогоор онцгой амжилт гаргасан хувь хүн болон байгууллагад олгосон Япон улсын гадаад харилцааны сайдын шагнал хүртсэн байна

Шао Зи Жун

/Олон улсын Шэнь Драгон Балетын Сургуулийн захирал/



Шао Зи Жун нь БНХАУ-ын Шанхайн Үндэсний Балет сургуулийг төгссөн.

2016 оноос БНХАУ-н Боловсрол, Соёл Урлаг, Спортын яамны Шанхайн олон улсын балетын уралдааны олон улсын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

Тэрээр сүүлийн жилүүдэд олон улсын балетын уралдаанд шүүгч, зөвлөхөөр ажиллах болсон ба 2016 оны Korea International Ballet уралдааны шалгалтын комисс, зочин төлөөлөгчөөр ажилласан байна.

Монголын балетын үндэсний I, II, III уралдаануудад шүүгчээр ажилласан.

Одоогоор ОУ-ын Шэнь Драгон Балетын Сургуулийн захирал, ОУ-ын Нэгдсэн Цахим Бүжгийн Уралдааны ерөнхийлөгч, Юнескогийн дэргэдэх CID ОУ-ын Бүжгийн Зөвлөлийн гишүүнээр ажиллаж олон улсад балетын зөвлөх, багш, тэмцээнүүдийн шүүгч, зохион байгуулагч болон бүжиг дэглээчээр идэвхтэй хувь нэмэр оруулж байна.

Ван Иен

/Сингапурын Иен Балетын Академийн үүсгэн байгуулагч, захирал/



Хатагтай Ван Иен 2003 онд Шанхайн бүжгийн сургуулийн балетын ангийг төгссөн. Шанхайн балетын компанид 10 жилийн турш гоцлол бүжигчнээр тэргүүлж, дэлхийн өнцөг булан бүрт тоглосон. Хатагтай Иен 2014 оноос хойш Сингапурын балетын сургуулиудын сүлжээ болох Иен Балетын Академийг үүсгэн байгуулж, уран сайхны удирдагчаар ажиллаж байна.

Хатагтай Иен нь Олон улсын балетын тэмцээний холбоонд Сингапурыг төлөөлж, шүүгчээр ажиллаж байсан туршлагатай бөгөөд Монголын балетын хөгжил сангийн зохион байгуулсан Олон улсын ба Үндэсний балетын тэмцээнүүд, Азийн элит бүжгийн тэмцээн (БНХАУ -ын Шэньжэнь, Чэнду), Олон улсын нэгдсэн цахим бүжгийн тэмцээнүүдэд шүүгчээр ажилласан байна.

Дугаржапов Доржо Васильевич

/Буриад Улсын Гавьяат Жүжигчин/



Буриадын Бүгд Найрамдах Улсын Автономит Мэргэжлийн Боловсролын Байгууллага,
Л.П. Сахянова, П.Т. Абашеев нарын нэрэмжит "Буриадын Бүгд Найрамдах Улсын
Бүжгийн Коллеж"-ийн захирал

Балетын жүжигчин

Бүжиг дэглээч багш (ГИТИС, Москва)

Соёл судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан

Туслах профессор

ОХУ -ын Соёлын яамны Хүний нөөцийн баазын шилдэг оролцогч



Уралдааныг зохион байгуулагчтай холбоо барих:

Монголын балетын хөгжил сан

БЗД, 26-р хороо, Их хүрээ өргөн чөлөө

726-р байр, Нарлаг төвийн 5 давхарт

77070808, 80810808

Email: mibc@mongolianballet.com

www.mongolianballet.mn

Уралдааны захирал МУГЖ Д. Алтанхуяг.

ТАНД АМЖИЛТ ХҮСЭЕ!

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: МОНГОЛЫН БАЛЕТЫН ХӨГЖИЛ САН

БАЛЕТЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО



ХАВСРАЛТ 1

1. УРАЛДААНЫ БҮРТГЭЛ

Хугацаа: 2021 оны 10 дугаар сарын 15-11 дүгээр сарын 15

Бүртгэлийн хугацаанд бүх оролцогчид ангиллын дагуу бүжгийн үзүүлбэрүүдийг болон цээж зураг, бүтэн бие гарсан зургийг файлаар мөн төрсний гэрчилгээний хуулбарыг бэлдсэн байна. Бэлдсэн файлуудаа өөрийн ОВОГ НЭР, БҮЖГИЙН НЭР, НАСНЫ АНГИЛАЛ гэсэн байдлаар нэрлэсэн байх шаардлагатай. Уралдааны цахим хуудсаар (www.mongolianballet.mn) нэвтэрч бүртгэлийн хуудас бөглөн, төрсний гэрчилгээний хуулбар, бичлэг болон зурган файлуудаа илгээнэ.

Мөн доорх QR кодыг гар утасны энгийн камераар уншуулан уралдааны бүртгэлийн хуудас руу шууд орох боломжтой.



Амжилттай илгээгдсэн, мөн бүх материал шаардлага ханган бүртгэгдсэн бол ажлын 1-5 хоногт бүртгэлтэй имэйл хаягаар нь баталгаажилт илгээнэ.

Цахим бүртгэл хэрхэн хийхийг мэдэхгүй, сүлжээний асуудалтай бол 77070808, 80810808 дугаарт холбогдон зөвлөгөө авна уу.

2. БҮХ БИЧЛЭГЭНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

- Зөвхөн mp4 видео файл хүлээж авна.
- Бичлэг тус бүрийн хэмжээ 250-500 мегабайтаас хэтрэхгүй байх. Дасгалын бичлэг 500-1500 мегабайтаас хэтрэхгүй байх.
- Бичлэгэн файлаа өөрийн ОВОГ НЭР, БҮЖГИЙН НЭР, НАСНЫ АНГИЛАЛ гэсэн байдлаар нэрлэсэн байна. Багийн төрөлд оролцож байгаа бол БАГИЙН НЭР, БҮЖГИЙН НЭР, НАСНЫ АНГИЛАЛ гэсэн байдлаар нэрлэсэн байна.
- Бүжгийн бичлэгэн дээр тусгай эффект ашиглахгүй, эвлүүлэг хийхгүй, оролцогчийн нэр, сургууль, багшийн нэр болон бусад текстийг эвлүүлэг



МОНГОЛЫН
БАЛЕТЫН
ҮНДЭСНИЙ
IV УРАЛДААН

хийн тавиагүй байх шаардлагатай. Зөвхөн дасгалын хэсгийн бичлэгийг хийхдээ дасгал тус бүрийг эвлүүлэн нийлүүлсэн байж болно.

- Хөгжим цэвэрхэн, дуу чимээгүй байх бөгөөд бичлэг хийсний дараа эвлүүлэн нэмсэн байж болохгүй.
- Бичлэгийг чичиргээнгүй хийхийн тулд камераа суурин дээр байршуулан бичлэгээ хийхийг зөвлөж байна.
- Камерыг байршуулахдаа оролцогчийн бүтэн бие орсон, хөдөлгөөн бүрэн харагдах өнцөгт байршуулж бичлэг хийнэ. Жишээ нь дасгалын хэсгийн бичлэг хийхдээ тулгуур модтой дасгалын хэсгийг диагональ байрлалаас, төвийн дасгалыг эгц урдаас авбал зохистой. Жишээ, заавар бичлэгийг уралдааны цахим хуудаснаас үзнэ үү.
- Бичлэгийг хөндлөн байрлалтайгаар хийнэ. Гэрэлтүүлэг сайтай танхим, эсвэл тайзнаа, Монголын балетын үндэсний 4-р уралдаанд зориулж шинээр хийсэн байх.
- Бүх бичлэгэнд багшийн болон хөндлөнгийн хүний яриа, дуу чимээ, мөн оролцогчоос бусад хүний дүрс ороогүй, толины тусгалд харагдаагүй байх дээр анхаарна уу.

3. ДАСГАЛЫН БИЧЛЭГЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА БА ЗӨВЛӨМЖ

Ганцаарчилсан төрөлд оролцогчид уралдаан зохион байгуулах хорооноос насны ангиллын дагуу олгогдсон дасгалыг хийж бэлдэн, бичлэг хийн, ОВОГ НЭР, ДАСГАЛ, НАС гэсэн байдлаар нэрлэн бусад бүжгийн бичлэг болон материалын хамт ирүүлнэ. Бичлэгийг нэг өдөрт хийх шаардлагатай ба олон өдрийн турш хийн эвлүүлсэн байж болохгүйг анхарна уу.

○ ЭМЭГТЭЙ ОРОЛЦОГЧИД

Дасгалын бичлэг хийхдээ оролцогч цулгуй, ханцуйгүй купальник, цайвар ягаан эсвэл биений өнгөтэй балетын трико болон зөөлөн чешкитэй байна. Бусад хувцас, дээгүүр цамц, хормой, гоёл чимэглэл, зүүлт гэх зэргийг хориглоно.

○ ЭРЭГТЭЙ ОРОЛЦОГЧИД

Цулгуй, бие барьсан хагас ханцуйтай цамц (футболка), хар өнгийн трико эсвэл бие барьсан богино өмд (шорт), зөөлөн чешкитэй байна. Эдгээр нь бие барьсан, цулгуй байх нь чухал бөгөөд аль нэг нь сул, дээрээ зураг бичвэртэй байж болохгүй.

МОНГОЛЫН БАЛЕТЫН ХӨГЖИЛ САН

Хавсралт 2. Монголын Балетын Үндэсний IV Уралдаанд зөвшөөрөгдөх вариациуд



Эмэгтэй	Эрэгтэй	Па де де
<ol style="list-style-type: none"> 1. Баядера Гамзатги вариаци, I-р үзэгдэл / Никия вариаци III-р үзэгдэл / 2. Цэнхэр нүдэн бүсгүй /Сванильда вариаци III-р акт/ Хүүхэлдэй 2-р үзэгдэл 3. Корсар Медора вариаци, II-р үзэгдэл Одалиск вариаци, III-р үзэгдэл /па-де-труа/ 4. Дон Кихот Китри вариаци, I,II,III,IV-р үзэгдэл / Variation of Queen of Dryads, Зүүдний вариаци, II-р үзэгдэл 5. Диана ба Актеон Диана вариаци 6. Эсмеральда Эсмеральда вариаци, II вариаци 7. Үр дүнгүй болгоомжлол Лиза вариаци, II-р үзэгдэл 8. Жензано цэцгийн баяр вариаци 9. Жизель – вариаци, I-р үзэгдэл 10. Арлекин-Арлекин, Коломбайн вариаци 11. Цөмөөхэй-Цөмөөхэй вариаци 12. Пахита-Вариациуд 13. Раймонда- / 15-18 / Раймонда вариаци I, II,III-р үзэгдэл 14. Нойрссон гүнж- / 15-18/ Аврора вариаци ,I,III-р үзэгдэл / Фея Сирень III-р үзэгдэл, пролог Хөх шувуу вариаци, III-р үзэгдэл 15. Хунт нуур – /15-18/ Одетта вариаци, II-р үзэгдэл Одиллия вариаци, III-р үзэгдэл па-де-труа, I-р үзэгдэл 16. Сильфида- /15-18/ Сильфида вариаци, II-р үзэгдэл 17. Шопениана-вальс вариаци 18. Наполи – Тересина вариаци, III-р үзэгдэл / вариациуд, III-р үзэгдэл 19. Гран-Па - вариаци 20. Талисман 21. Fairy Doll-Doll 	<ol style="list-style-type: none"> 1. Цэнхэр нүдэн бүсгүй Франц вариаци, III-р үзэгдэл 2. Корсар Конрад вариаци, II-р үзэгдэл Боолын вариаци, I-р үзэгдэл 3. Дон Кихот Базиль вариаци, III-р үзэгдэл 4. Эсмеральда Фрелло вариаци 5. Дэггүй Лиз Коллин вариаци, II-р үзэгдэл 6. Дженцано цэцгийн баяр вариациуд 7. Жизель тариачны вариаци, I-р үзэгдэл Альберт вариаци, II-р үзэгдэл 8. Пахита - вариациуд 9. Раймонда Variation of Jean de Brienne, Act III 10. Нойрссон гүнж Дезире вариаци, III-р үзэгдэл Хөх шувуу вариаци, III-р үзэгдэл 11. Хунт нуур Па де труа вариаци, I-р үзэгдэл Зигфрид вариаци, II,III-р үзэгдэл 12. Сильфида Жеймс вариаци, II-р үзэгдэл 13. Парисын дөл вариациуд 14. Баядере Солор вариаци 15. Цөмөөхэй Цөмөөхэйн вариаци, II-р үзэгдэл 16. Наполи – Женнаро вариаци, I-р үзэгдэл / вариациуд III-р үзэгдэл 17. Гран-па -вариациуд 18. Диана ба Актеон - Актеон вариаци 	<ol style="list-style-type: none"> 1. Жизель Тариачны па де де I-р үзэгдэл Гран па де де Жизель ба Альберт, II-р үзэгдэл 2. Цөмөөхэй Гран па де де, II-р үзэгдэл 3. Дон Кихот Гран па де де, /хуримын хэсэг Китри&Базиль / III-р үзэгдэл 4. Нойрссон гүнж – Гран па де де, Хөх шувуу III-р үзэгдэл Гран па де де Аврора ба Ханхүү III-р үзэгдэл 5. Корсар – Гран па де де, Боолын охин ба Худалдаачин I-р үзэгдэл Гран па де де Медора ба Боол, II-р үзэгдэл 6. Хунт нуур – Гран па де де, III-р үзэгдэл /хар хун/ 7. Эсмеральда – Гран па де де, Эсмеральда&Фрелло 8. Парисын дөл – Гран па де де Жеанна&Филиппе, IV-р үзэгдэл 9. Сильфида Waltz No.7 гран па де де 10. Цэнхэр нүдэн бүсгүй Хуримын гран па де де Сванильда&Франц, III-р үзэгдэл 11. Раймонда Гран па де де, III-р үзэгдэл 12. Дженцано цэцгийн баяр Гран па де де 13. Дэггүй Лиз Гран па де де, Никия&Солор III-р үзэгдэл 14. Пахита – Гран па де де 15. Grand pas Classique – гран па де де 16. Сильфида – Гран па де де, II-р үзэгдэл 17. Наполи – Гран па де де, III-р үзэгдэл 18. Диана ба Актеон – Гран па де де